БАТЛАВ
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ С.СОЁЛЧХҮҮ

## ОРХОН АЙМГИЙН ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Арга хэмжээ | Хугацаа | Хариуцах байгууллага | Хамтран хэрэгжүүлэх байгууллага | Санхүүжилт /сая.төг/ | Хүрэх үр дүн |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. Судалгаа, мэдээ, тайлан гаргах** | | | | | | |
| 1. | Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагуудын мэдээллийн сан бүрдүүлэх | Жилдээ | Аймгийн ЗДТГ ХБТХОХ | БОГ, ГХБХБГ, Баян-Өндөр сумын ЗДТГ, Жаргалант сумын ЗДТГ | - | Мэдээллийн сантай болсон байна. |
| 2. | Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжээс орон нутгийн төсөвт хүлээн авсан татвар, төлбөр, хандив, дэмжлэгийн мэдээ гаргах | Улирал, жилээр | Аймгийн ЗДТГ СТСХ | Татварын газар, Баян-Өндөр сумын ЗДТГ, Жаргалант сумын ЗДТГ | - | Иргэдэд ил тод мэдээлэх ажил сайжирсан байна. |
| 3. | Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагуудын 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОАЖСайдын 2019 оны А/618 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу гүйцэтгүүлж, батлуулан хэрэгжилтийг хангуулж ажиллах | Жилдээ | БОГ | ХБТХОХ, ГХБХБГ, Баян-Өндөр сумын ЗДТГ, Жаргалант сумын ЗДТГ | - | Байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөлөл буурна. |
| 4. | Уул уурхайн үйлдвэрлэлийн нөлөөллийн бүсэд амьдарч байгаа айл өрх, иргэд, мал сүрэгт аюултай хог хаягдал, агаарын бохирдол, бусад сөрөг нөлөөллөөс үүсэж буй хор хөнөөлийн талаарх мэдээ, судалгаа гаргах | Жилдээ | БОГ, ЭМГ, Стандарт хэмжил зүйн хэлтэс | Аймгийн ЗДТГ, ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүд, "Эрдэнэт хүмүүний эв нэгдэл" ТББ, "Төр иргэн түншлэл" ТББ, иргэд | - | Судалгааны сан бий болсон байна. |
| **Зорилт 2. Тайлан мэдээг иргэдэд нээлттэй, ил тод мэдээлэх** | | | | | | |
| 5. | Олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурвалжилга, мэдээ явуулах | Жилдээ | Хэвлэл мэдээллийн байгууллагууд, | Аймгийн ЗДТГ, БОГ | - | Мэдээлэл олон нийтэд хүрсэн байна. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | "Эрдэнэт хүмүүний эв нэгдэл" ТББ,<br>"Төр иргэн түншлэл" ТББ | | | |
| 6. | Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэжгийн мэдээллийг https://erdenet.mn/ сайтад өөрчлөлт орсон тухай бүр байршуулах. | Жилдээ | Аймгийн ЗДТГ ХБТХОХ | - | - | Мэдээлэл олон нийтэд хүрсэн байна. |
| 7. | ereport.eitimongolia.mn сайтад тайлан мэдээллийг хугацаанд нь оруулах | 2025.04.15 -06.15 | Аймгийн ЗДТГ СТСХ | - | - | Тайлан мэдээг бүрэн оруулсан байна. |
| **Зорилт 3. Хамтын ажиллагаа, түншлэл хөгжүүлэх, оролцогч талуудын чадавх бэхжүүлэх** | | | | | | |
| 8. | Орхон аймаг, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, "Ачит-Ихт" ХХК, "Эрдмин" ХХК, "Зэс эрдэнийн хувь" ХХК-тай байгуулсан хамтран ажиллах гэрээ, төлөвлөгөө түүний хэрэгжилтийн тайланг нээлттэй тайлагнах | Жилдээ | Аймгийн ЗДТГ | Хэвлэл мэдээллийн байгууллагууд,<br>"Эрдэнэт хүмүүний эв нэгдэл" ТББ,<br>"Төр иргэн түншлэл" ТББ | - | Хамтран ажиллах гэрээнд иргэдийн зүгээс тавих хяналт, мэдээлэл сайжирч, холбогдох мэдээллээр хангагдана. |
| 9. | Хуульд заасан мэдээллийг үнэн зөв гаргаж нийтэд мэдээлээгүй ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч, тэдний гэрээт туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжид зөрчлийн тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх | Жилдээ | БОГ | Аймгийн ЗДТГ | - | Мэдээллийг үнэн зөв мэдээлсэн байна. |
| 10. | Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчээс орон нутгийн төсөвт 2025 онд төлж байгаа татвар, төлбөр, хураамж, торгууль зэрэг орлого болон аймаг, сумын ЗДТГ, төсөвт байгууллагад хандивлаж байгаа мөнгөн болон мөнгөн бус хөрөнгийн тайланг холбогдох маягтын дагуу жил бүр гаргаж нийтэд мэдээлэх, журмын дагуу тайлагнах | 4-р улиралд | Аймгийн ЗДТГ СТСХ | Татварын хэлтэс, Баян-Өндөр сумын ЗДТГ, Жаргалант сумын ЗДТГ, орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагууд | - | Мэдээллийг үнэн зөв, хугацаанд нь мэдээлсэн байна. |
| 11. | Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах, дэд зөвлөлийг чадавхжуулах сургалт зохион байгуулах | Жилдээ | Аймгийн ЗДТГ | БОГ | - | Үйл ажиллагааны хяналт сайжирна. |